

БАТАЛСАН:
ТӨЛӨВЛӨЛТ, ЗОХИОН БАЙГУУЛАЛТЫН
ХЭЛТСИЙН ДАРГА ДЭД ХУРАНДАА
Х.САРУУЛ

АЖЛЫН ДААЛГАВАР

- Нийслэлийн ШГА, 21 аймаг дах шийдвэр гүйцэтгэх албаны дансыг харилцдаг банкнуудын CORPRATE GATEWAY-н үйлчилгээнд холбох;
- ШГА-ны бүртгэл хяналтын нэгдсэн системд харьяа газар, хэлтсийн нягтлан бодогч нарт олгогдсон хандах эрхэнд хяналтын модулийн хөгжүүлэлт хийх;
- Төлбөр хүлээн авагчийн дансны мэдээлэл удирдах, хянах;
- Төлбөр хүлээн авагчийн дансны мэдээлэлийг хянах, банктай холбож шалгах;
- Банкруу ШГА-ны төлбөрийн модулийн системээс нэхэмжлэхийн мэдээлэл дамжуулах сервисийн хөгжүүлэлт, харилцдаг бүх банкнууд нэхэмжлэхийн дугаараар төлбөр төлөх хөгжүүлэлтийг хийх. Банк болон төлбөрийн систем гүйцэтгэгч байгууллагууд хамтарсан тест, туршилтыг үе шаттай гүйцэтгэх, нэвтрүүлэх;
- Банк нэхэмжлэхийн үнийн дүнгээс хэтэрсэн гүйлгээ хийлгэхгүй байх нөхцөлийг хангахын түлд нэхэмжлэхийг төлбөрийн системд удирдах, илүү үнийн дүнтэй болон гүйлгээний утга танигдахгүй гүйлгээг илрүүлэх, нягтлан болон шийдвэр гүйцэтгэгчид мэдэгдэх;
- CORPRATE GATEWAY-ээр дамжуулан банкны харилцахын дансны орлогын гүйлгээг чагнах, мөнгө орсон даруйд нэхэмжлэхийн төлбөртэй холбож шийдвэр гүйцэтгэгчид мэдэгдэл илгээх;
- Төлбөрийн даалгавар үүсгэх, хэвлэх боломжоор хангах. Төлбөрийн даалгавар цахим хэлбэрээр шат дамжлагын дагуу баталгаажуулах;
- Баталгаажсан төлбөрийн даалгавар CORPRATE GATEWAY системээр биелэгдэх гүйлгээ илгээгдэх, дамжуулан төлбөр гаргах, банкны сервис холбох зэрэг ажлууд хийгдэнэ.

Төлбөрийн гүйлгээг цахимжуулах, мэдээлэл солилцох зураглал:



Дээрх хөгжүүлэлт хийгдсэнээр дараах ач холбогдолтой: Үүнд

- Хамтын ажиллагаатай байгууллагын ажилтан, алба хаагчдын ажлын ачаалал багасах,
- Шийдвэр гүйцэтгэгчийн төлбөрийн гүйлгээ хийхэд зарцуулах цаг багасах, шийдвэр гүйцэтгэх ажиллагаанд зарцуулах цаг ихэснэ;
- Төлбөрийн гүйлгээ хийхэд зарцуулагдах цаас, принтерын хор зэрэг бичиг хэргийн урсгал зардлыг хэмнэх;
- Шийдвэр гүйцэтгэх ажиллагаатай холбоотой өргөдөл, гомдлын тоо багасах;

- Төлбөр төлөгч өөрийн төлбөрийн хэмжээг тогтмол авах, хүссэн газраас төлбөр төлөлт хийх;

- Төлбөр авагчид үзүүлэх үйлчилгээ түргэн шуурхай, хугацаа алдахгүй шилжүүлэг хүлээн авах, хянах;

- Зөвхөн аль нэг банкны дансанд төвлөрөх болон нэр, данс зөрүүтэй, зориулалт тодорхойгүй гэх асуудал багасч, бүх арилжааны банкуудаар дамжин гүйлгээг хийх;

- Арилжааны банк хоорондох мөнгөний урсгал, нийлүүлэлт нэмэгдэх;

- Олон шат дамжлага цахим хэлбэрээр явагдаж, ашиг сонирхолын зөрчил, хууль бус үйл ажиллагаанаас урьдчилан сэргийлэх;

- Мөн шийдвэр гүйцэтгэх ажиллагаанд оролцогч нар ШГА талууд аппликейшнаар дамжуулан өөрт холбогдох гүйцэтгэх баримт бичигтэй танилцах, шуурхай хүргэх, төлбөрийн гүйлгээнд хяналт тавьж, хуульд заасан эрхээ эдлэх боломж бүрдэнэ.

БОЛОВСРУУЛСАН:
ХОШУУЧ



Д.ГАНТУЛГА

ХОШУУЧ



Г.ЖИГЖИД